



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2022 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”-д
ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: /ДУА-2023/28-10-ШТА-ГА/

Дундговь дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудитор
Р.Мөнхтогтох Утас: 70592439

Аудитын менежер: Х.Наранцацрал
Утас: 70592225

Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Батсайхан

Аудитор Б.Гантуяа Утас: 7059-2208,

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим
хуудас: www.audit.mn

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгс	3
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4-6
	Дүрслэлийн товьёг	7
Дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох	<u>Бүлэг А. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хууль, хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлж төлөвлөсөн байна.</u>	8
Аудитын менежер Х.Наранцацрал	А.1 Төсөл арга хэмжээ нь Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй 18 төсөл арга хэмжээ уялдаагүй байна.	8-10
Ахлах аудитор Т.Батсайхан	А.2 Төсөл арга хэмжээний эдийн засгийн үр ашгийг тооцож төлөвлөөгүй байна.	10-11
Аудитор Б.Гантуяа	<u>Бүлэг Б. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хууль журмын дагуу хэрэгжүүлж байна.</u>	11
	Б.1 Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.	11-12
	Б.2 Зарим төсөл арга хэмжээний гүйцэтгэл удааширалтай байна.	12-13
	Б.3 Санхүүжилтийг хууль, журамд нийцүүлэн олгосон байна.	13
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	Б.4 Захиалагчийн хяналтыг 6 төсөл арга хэмжээнд 8 удаа гүйцэтгэсэн байна.	14
ХАЯГ:	Б.5 Төсөл арга хэмжээг хүлээн авах комиссыг хууль журмын дагуу томилж, ашиглалтад ашиглалтад хүлээн авсан байна.	14-15
Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 209 тоот	<u>Бүлэг В. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хөгжлийн бодлоготой үялдүүлж төлөвлөөгүй, хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй, зарим төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд гүйцэтгээгүй удааширалтай байна.</u>	15
2023 оны 4 дугаар сар	Б.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хуульд нийцүүлэн төлөвлөөгүй байна..	15-18
	Б.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт үр дүнтэй ч шугамын өргөтгөлийн ажил удааширалтай, гэрээний хугацаандаа хэрэгжээгүй байна.	18-22
	Дүгнэлт	
	Зөвлөмж	23
	Шалгагдагч байгууллагын санал тайлбар	24
	Тайлангийн хавсралтууд	25-26 27-36



Тайлан баталгаажуулах тушаал



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 07

Мандалговь

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх үүрэг”-ийн 1.1, 1.3, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 9-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан / ДУА-2023/28-10-ШТА-ГА / -г нэгдүгээр, аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт (акт, албан шаардлага)-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

1. “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, аймгийн Засаг дарга, ИТХ-ын даргад тус тус хүргүүлсүгэй.

2. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2023 оны 11 дугаар сарын 20-ны дотор Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг Дундговь аймгийн, Засаг дарга /Ц.Мөнхбат/, аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Адьяасүрэн/, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Бархасмаа/ нарт зөвлөсүгэй.

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон 2023 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг Аудитын гуравдугаар нэгжийн ахлах аудитор /Т.Батсайхан/ аудитор /Б.Гантуяа/ нарт үүрэг болгосугай.

Р.МӨНХТОГТОХ

ТОВЧИЛСОН ҮГС

АДБОУБ	Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗД	Аймгийн Засаг дарга
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БСШУСС	Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайд
БСШУСЯ	Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын яам
БТСГ	Биеийн тамир, спортын газар
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТХДЖТ	Төв халхын дуулалт жүжгийн театр
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХБТХО	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх үндэслэл, бүрэн
эрх:

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/04 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-нд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилт:

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн.
Үүнд:

- ✓ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн төлөвлөсөн эсэх?
- ✓ Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа хуульд нийцсэн эсэх?
- ✓ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт үр дүнтэй хэрэгжсэн эсэх?

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

Аудитад ашигласан
шалгуур үзүүлэлт:

- ✓ Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт,
- ✓ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль,
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- ✓ Барилгын тухай хууль,
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- ✓ “Алсын хараа” 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого,
- ✓ Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”
- ✓ Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалаар батлагдсан “Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”
- ✓ Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- ✓ Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт;
- ✓ Дундговь аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, 2022 оны аймаг хөгжүүлэх төлөвлөгөө;
- ✓ Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”,

Аудитын хамарсан хүрээ:

Аудитын арга зүй:

Аудит хийх багийн
бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитын дүн

- ✓ Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам, болон холбогдох аргачлалууд”;
- ✓ Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.

Аудитыг Дундговь аймагт 2022 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүн, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлд үндэслэн хийсэн.

Аудитын явцад объект дээр ажиллаж, барилга байгууламжийн ажлын бодит гүйцэтгэлийг газар дээр нь шалгасан.

Аудитад улсын төсвөөс 2022 онд санхүүжүүлсэн, төсвийн ерөнхийлөн захирагчид эрх шилжин хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын 9 төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт болон эдгээр төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч нарын холбогдох үйл ажиллагааг хамруулав.

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөрт дурдсан хугацаанд нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан.

Аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналт хэрэгжүүлэн, аудитын 3-р нэгжийн ахлах аудитор Т.Батсайхан, аудитор Б.Гантуяа нар 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийг дуустал хугацаанд аудитыг хийж гүйцэтгэлээ.

Аудитаар нийт 446.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 446.0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 4 хугацаатай албан шаардлага, аймгийн Засаг даргад 5, Санхүүгийн хяналт, дотоод аудитын

албанд 1, ОНӨГ-т 1, нийт 7 заалт бүхий зөвлөмж тус тус хүргүүлээ.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Дундговь аймгийн хэмжээнд 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 80,549.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 28 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төсөв батлагдсан байна.

Үүнээс 12,076.0 сая төгрөгийн 9 төсөл арга хэмжээ нь эрх шилжин ирсэн, 68,473.3 сая төгрөгийн 19 төсөл арга хэмжээ нь эрх шилжин ирээгүй байна. Эрх шилжин ирсэн төсөл арга хэмжээний хувьд 2022 онд 2,997.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Эрх шилжин ирсэн 9 төсөл арга хэмжээнээс барилга, байгууламжийн 6, тоног, төхөөрөмжийн 3 ажил байна.

Тайлант хугацаанд хэрэгжих нийт 9 төсөл, арга хэмжээний 3 нь өмнөх оноос үргэлжлэн хэрэгжсэн, 3 нь шинээр хэрэгжсэн төсөл арга хэмжээ бөгөөд үүнээс 3 төсөл, арга хэмжээ нь он дамжин хэрэгжинэ.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор 21 төсөл арга хэмжээнд 1.5 тэрбум төгрөг, 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 27 дугаар тогтоолоор 2022 оны төсөвт өөрчлөлт оруулж орон нутгийн хөрөнгө оруулалтаар 1.9 тэрбум төгрөгийн 32 арга хэмжээг санхүүжүүлэхээр баталжээ.

Нийт санхүүжилтийн 2.1 хувийг барилга, байгууламжийн 1, 4.9 хувийг тоног төхөөрөмжийн 2, 47.8 хувийг их засварын 15, 45.2 хувийг ТЭЗҮ боловсруулах 14 төсөл арга хэмжээнд тус тус зарцуулахаар байна.

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1,2	УТХО-аар хийгдсэн хөрөнгө оруулалт салбараар /2017-2022/	9

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн бодлогын баримт бичигт УТХО-аар хэрэгжүүлсэн ТАХ нийцсэн байдал	7
Хүснэгт 2	“Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичгийн зорилтоор нь ангилсан байдал	8
Хүснэгт 3	Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байдал	

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн хөгжлийн 2021 оны жилийн төлөвлөгөөтэй уялдсан байдал	26-28
Хавсралт 2	Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны /Үнэлгээний хорооны хугацаа/ судалгаа	29
Хавсралт 3	Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны /Тендерийн хугацаа / судалгаа	30
Хавсралт 4	Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны /Гэрээ байгуулах хугацаа / судалгаа	31
Хавсралт 5	Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны /Тендерийн үр дүн/ судалгаа	32

БҮЛЭГ А.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлж төлөвлөсөн байна.

А.1 Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй төсөл арга хэмжээний 84.5-90 хувь нь уялдсан байна.

А.1.1 Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар Дундговь аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 80,549.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 28 төсөл арга хэмжээнээс тайланд онд 17,622.4 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Дээрх 2022 онд хэрэгжих нийт төсөл арга хэмжээний 68,473.3 сая төгрөгийн 19 төсөл арга хэмжээ эрх шилжээгүй, 12,076.0 сая төгрөгийн 9 төсөл арга хэмжээ эрх шилжиж ирсэн байна.

/Хүснэгт 1/

Бодлогын баримт бичигт УТХО-ТАХ нийцсэн байдал	Нийцсэн			Нийцээгүй		
	тоо	дүн / сая. төг/	Хувь	тоо	дүн / сая. төг/	Хувь
Алсын хараа 2050	25	72,499.3	90%	3	8,050.0	10.0%
2021-2025 онд Аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	21	66,577.1	82.7%	7	13,972.2	17.3%
2022 оны хөгжлийн төлөвлөгөө	20	68,077.1	84.5%	8	12,472.2	15.5%

Эх сурвалж: ТАГ

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын нийт хэрэгжих 72,499.3 сая төгрөгийн 25 төсөл арга хэмжээ “Алсын хараа-2050”, 66,577.1 сая төгрөгийн 21 төсөл арга хэмжээ нь “Аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл/2021-2025/”, 68,077.1 сая төгрөгийн 20 төсөл арга хэмжээ нь “Аймгийн хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөө”-д тусгагдсан байна.

Харин 8,050.0 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээ нь “Алсын хараа-2050”, 13,972.2 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээ нь “Аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл /2021-2025/”, 12,472.2 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээг “Аймгийн хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөө”-нд тус тус тусгаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.1.4¹ -д заасныг зөрчиж байна.

Эдгээр асуудлууд нь төсөл арга хэмжээг Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-тай аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, баримт бичигтэй уялдуулан жил бүрийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхгүй байгаатай холбоотой байна./Хавсралт 1

¹ / Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ журмын 3.1.2-т заасан төслийн саналыг ирүүлэхдээ дараах шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг судалж, холбогдох тайлан болон баримт бичгийг хавсаргасан байна:

3.1.4.1.бодлогын баримт бичигт тусгагдсан байдал;

3.1.4.2.Хөгжлийн урт, дунд, богино хугацааны баримт бичгүүдтэй нийцэж буй байдал;


3.1.4.3.хэрэгцээ шаардлага, үндэслэл;

3.1.4.4.мэргэжлийн байгууллагын дүгнэлт;

3.1.4.5.төслийн зардлыг бүрэн зөв тооцсон эсэх;

3.1.4.6.санхүүжилтийн эх үүсвэрийн төрөл.

А.1.2 Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 28 төсөл арга хэмжээний саналыг Сангийн яам болон бусад төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлсэн боловч дээрх төсөл арга хэмжээний саналд үндэслэгдээгүй 3 төсөл арга хэмжээ батлагдаж ирсэн байна. Энэ нь тайлант онд батлагдаж, эрх шилжиж ирсэн нийт төсөл арга хэмжээний төсвийн 24.8 хувийг эзэлж байна.



Төсвийн ерөнхийлөн захирагч нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээг Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй нийцүүлэн төлөвлөсөн ч орон нутгаас хүргүүлсэн саналыг хасаж, Улсын Их Хурлын гишүүдийн санаачилгаар хэрэгжүүлэх эрэмбэлэгдээгүй төсөл арга хэмжээг баталсан байна.


Энэ нь орон нутгийн хэрэгцээ шаардлагад үндэслээгүй, судалгаа хийгээгүй төсөл арга хэмжээг баталж хэрэгжүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулах сөрөг үр дагавартай байна

Тайланд онд эрх шилжин ирсэн ТАХ-ний 49.9% БШУС-ын багц эзэлж байгаа бөгөөд хөрөнгө оруулалт хийгдсэн салбарын сүүлийн 5 жил /2018-2022 он/-ийн судалгаагаар нийт санхүүжилтийн дийлэнх буюу 31.9-51.1 хувийг боловсролын салбарт, 15.7-48.9 хувийг дэд бүтцийн салбарт, 19.5-32.5 хувийг эрүүл мэндийн салбарт зарцуулж, хамгийн бага буюу 0.3-18.6 хувийг соёл, спорт, хөдөө аж ахуй болон бусад салбарт зарцуулсан байна. /График: 1,2/

/График:1/



/График:2/



Иймд хөрөнгө оруулалт бага хийгдэж байгаа салбарын хэрэгцээг судалж аймгийн хүн ам, нийгэм, эдийн засгийн үзүүлэлт болон тухайн салбарын үндсэн үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж, барилга, байгууламжийн чанар, насжилт, хүчин чадал зэргийг тооцон үзэж хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөж байх шаардлагатай байна.

А.1.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 28 төсөл арга хэмжээг “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичгийн зорилтоор нь ангилбал дараах байдалтай байна.

/Хүснэгт 2/

№	Зорилт	ТАХ-ны тоо	Эзлэх хувь
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	3	10.7
2	Хүний хөгжил	14	50.0
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	4	14.3
4	Эдийн засаг	1	3.6

5	Засаглал	-	-
6	Ногоон хөгжил	1	3.6
7	Амар тайван, аюулгүй нийгэм	-	-
8	Бүс орон нутгийн хөгжил	5	17.9
Нийт		28	100.0

Эх сурвалж: ТАГ

Хүснэгтээс харахад “Хүний хөгжил”-ийн зорилтод чиглэсэн 14 төсөл, арга хэмжээ буюу 50 хувийг төлөвлөсөн бол, “Засаглал”, “Амар тайван, аюулгүй нийгэм” -д чиглэсэн төсөл, арга хэмжээг 2022 онд огт төлөвлөөгүй байна.

Энэ нь “Амар тайван, хүмүүнлэг нийгмийг цогцлоож”, “Ардчилал, шударга ёсны засаглалыг бэхжүүлэх” зорилтыг хангахгүй байна. Мөн Сангийн яам болон төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлсэн Дундговь аймагт 2022 онд УТХО-аар хэрэгжүүлэх 28 төсөл арга хэмжээний саналд дээрх 2 зорилтыг хэрэгжүүлэх санал төлөвлөөгүй байна.

Иймд УТХО-оор хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг хүргүүлэхдээ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3²-т заасныг баримталж байх нь зүйтэй байна.

А.2 Төсөл арга хэмжээний эдийн засгийн үр ашгийг тооцоож төлөвлөөгүй байна.



А.2.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хийгдэх эрх шилжиж ирсэн 9 төсөл арга хэмжээ нь хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжтойгоор төлөвлөсөн байна. Шинээр болон шилжих хөрөнгөөр хийгдсэн 6 барилга байгууламжийн 4 барилга байгууламжийг Сангийн сайдын 2018 оны 295-р тушаалаар баталсан журмын дагуу үнэлж, эрэмбэлсэн байна.

А.2.2 Харин төсөл арга хэмжээний нийгэм, эдийн засгийн үр ашгийг тооцоогүй, үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоо болон төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргаагүй, техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2³ дахь хэсэг болон холбогдох тогтоомжийг мөрдөж ажиллаагүй, төсөл арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй удаашрах, төсөвт нөлөөлөх ачааллыг нэмэгдүүлэх үр дагавартай байна.

Иймд УТХО-оор хийгдэх төсөл арга хэмжээг эрэмбэлэхдээ нийгэм, эдийн засгийн үр ашиг, шинээр ашиглалтад орж байгаа үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо түүнийг санхүүжүүлэх эх үүсвэр, төсөвт нөлөөлөх ачааллыг тооцоож, холбогдох журмын шалгуурыг хангасан ТАХ-г хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

А.2.3 Эрх шилжиж ирсэн 6 барилга байгууламж, 3 тоног төхөөрөмж нийт 9 төсөл арга хэмжээ байгаагаас 6 барилга байгууламжийн зураг төсвийн үнийг батлуулсан боловч “Гудамж, талбайн тохижилт, ногоон байгууламж”, “Наадмын талбайн дуусгал”-ын зураг төсөл боловсруулах ажлын даалгавар, баталсан зураг төсвийг боловсруулсан огноо тодорхойгүй байна. Төсөл, арга хэмжээг хуулийн шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн байдлын судалгаагаар ТЭЗҮ боловсруулсан баримт бичиг байхгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.4⁴-т заасныг зөрчсөн байна.

² 5.1.3.нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх;

³ Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна/

⁴ /Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана./

Иймд мэргэжлийн байгууллагуудад зураг төсөл боловсруулахдаа объект дээр бодит хэмжилт хийн, ашиглагч байгууллагын саналыг авч, тооцоо судалгаа хийж байх, ажил хариуцсан албан тушаалтнуудыг хариуцлагатай ажиллах талаар чиглэл өгч, хяналт тавин ажиллах шаардлагатай байна.



БҮЛЭГ Б. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа хуульд нийцэж байна.

Б.1 Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.

Б.1.1. Дундговь аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 12,076.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх шилжиж ирсэн байна.


Үүнээс 4,800.0 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээг 2019 онд, 7,276.0 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээг 2022 оны эхний улиралд худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар эрх шилжүүлсэн байна.

Шинээр эхлэх төсөл арга хэмжээний тайлант онд хэрэгжих 6 төсөл арга хэмжээнээс он дамжин хэрэгжих 4 төсөл арга хэмжээ байна. 2022 онд шинээр эрх шилжин ирсэн нийт 6 төсөл арга хэмжээний хувьд эрх шилжин ирсэн хугацаанаас хойш 41-83 хоногийн дараа, үнэлгээний хороо байгуулах төлөвлөсөн өдрөөс хойш 5-47 хоногийн дараа үнэлгээний хороо байгуулж хугацаа алдсан байна. /Хавсралт 2/

ТАХ-г хэрэгжүүлэх боломжтой хугацаанд эрхийг шилжүүлсэн боловч зарим ТАХ-ний тендер шалгаруулалт зохион байгуулахдаа хугацаа алдсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 7 төсөл арга хэмжээг нээлттэй тендерээр, “Ноос хяргах байгууламж, тоног төхөөрөмж”, “Гудамж, талбайн тохижилт, ногоон байгууламж” 2 төсөл арга хэмжээг түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр худалдан авах ажиллагааг цахимаар зарлаж зохион байгуулсан байна. Эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээний тендерийг төлөвлөсөн хугацаанаас 7-68 хоногийн дараа зарласан байна. /Хавсралт 3/

Бүх ТАХ-ний тендер хүлээж авах эцсийн хугацаа нь хуульд⁵ заасан шаардлагын дагуу хугацаандаа тендерийн баримт бичиг хүлээн авсан байна. Мөн тендерт зарцуулсан нийт хугацаа нь тендерийн хүчинтэй хугацаанд үнэлгээний хорооны дүгнэлт гарсан байна.



Гэрээ байгуулахаар төлөвлөсөн хугацаанаас 58-76 хоногийн дараа төсөл арга хэмжээнүүдэд гэрээ байгуулах эрх олгосон байна. Сайнцагаан сумын 150 ортой цэцэрлэгийн барилга, Их соёл-Эх үндэс төсөл хөтөлбөрийн хугацаа 72-76 хоногоор буюу 2 сараас дээш хугацаагаар хэтэрсэн байна.

Төлөвлөсөн хугацаанаас 7-12 хоногийн дараа тендерт шалгарсан компанитай гэрээ байгуулсан байна. /Хавсралт 4/

Энэ нь ХАА зохион байгуулах хугацааг төлөвлөхдөө тухайн ТАХ-ны цар хүрээ, онцлог шинж чанар, худалдан авах ажиллагаанд мөрдөх журам, санхүүжилтийн хуваарь зэргийг харгалзан үзэлгүй бүх ТАХ-г ижил цаг хугацаанд төлөвлөсөнтэй холбоотой байна. Төсөл арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй удаашрах, үр дагавартай байна.

⁵ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 24.3 Нээлттэй тендер шалгаруулалтын тухайд тендер хүлээн авах эцсийн хугацааг 30 буюу түүнээс дээш хоногоор тогтооно.

Иймд ХАА-нд мөрдөх хугацааг төлөвлөхдөө төсөл арга хэмжээний цар хүрээ, онцлог шинж чанар, худалдан авах ажиллагаанд мөрдөх журам, санхүүжилтийн хуваарь зэргийг харгалзан үзэж байх, төлөвлөгөөний дагуу ХАА-г зохион байгуулж байх шаардлагатай байна.

Б.1.2 Тендерийн бичиг баримт бичгийг хууль журмын дагуу боловсруулж бэлтгэсэн боловч зарим төсөл арга хэмжээнүүд хэрэгжиж дуусаагүй шалтгаанаар үдэж цэгцлээгүй, эмх цэгц муутай байлаа. Энэ нь баримт материал алдагдах, архив, бичиг хэргийн шаардлагыг хангахгүй үр дагаврыг бий болгож байна.



Б.1.3 Тайлант онд нийт 9 төсөл арга хэмжээг нээлттэй аргаар тендер шалгаруулалт зохион байгуулж 7 тендер амжилттай болж 2 тендер буюу “Говь-Угтаал сумын Спорт залны барилга”, “Эрдэнэдалай сумын хатуу хучилттай 2 км авто зам”-ын ажлуудыг 2 удаа тендер шалгаруулалт зохион байгуулж, “Эрдэнэдалай сумын хатуу хучилттай 2 км авто зам”-ын тендерт оролцогч байгууллага ирээгүй учир шууд гэрээ байгуулсан байна. /Хавсралт 5/

Б.2 Зарим төсөл арга хэмжээний гүйцэтгэл удаашралтай байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх 1,940.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Наадмын талбайн дуусгал”-ын барилга, байгууламжийг 2019 оны 08 дугаар сарын 07-ноос эхлүүлэн 2020 оны 10 дугаар сарын 26-д хүлээлгэн өгөхөөр анхны гэрээ байгуулагдсан байна. Цар тахлын улмаас хилийн хориг тавигдсан шалтгаанаар гэрээг 2020 оны 11 дүгээр сарын 06, 2022 оны 07 дугаар сарын 06-д тус 2 удаа сунгаж, барилгын ажлыг Барилгын тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.1⁶-т заасны дагуу хугацаанд гүйцэтгэж хүлээлгэн өгсөн байна.

Бусад 2022 онд хэрэгжиж дуусах 3 төсөл арга хэмжээний гэрээний хугацааг 2023 онд гүйцэтгэж дуусгахаар сунгасан байна. “Говь-Угтаал сумын Спорт залны барилга” Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн №А/69, “Эрдэнэдалай сумын хатуу хучилттай авто замын ажил” Зам тээвэр, хөгжлийн сайдын 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн №08 тоот тушаалуудаар эрх шилжиж ирсэн байна. “Говь-Угтаал сумын спорт заалны барилга”-ын ажил 853.2 сая төгрөгийн төсөвтэй 29 хувийн гүйцэтгэлтэй ба ажлыг гүйцэтгэгч “Бум констракшн” ХХК нь 2019, 2020 онд олон ажил зэрэг гүйцэтгэсэн шалтгаанаар ажил нь хийгдээгүй 2020 онд 500.0 сая төгрөгийн санхүүжилтийг дээд шатны төсөвт татуулж 2021 онд улсын төсөвт санхүүжилт батлагдаагүй байна. Харин 2022 онд улсын төсөвт 500.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж, гэрээг сунгаж тайланд онд ажил хийгдсэн байна. Энэ 2 төсөл, арга хэмжээний гүйцэтгэл удаашралтай байна.

Б.2.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн “Ижий говь” төсөл арга хэмжээний 997.7 сая төгрөг, “Их соёл-Эх үндэс” төсөл арга хэмжээний 798.3 сая төгрөг, “Шинэ хөдөө” төсөл хөтөлбөрийн тайлант онд нийлүүлэгдэх 199.9 сая төгрөг, нийт 1,995.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлснийг захиалагчийн баталсан техникийн тодорхойлолттой тулгаж, тоног

⁶ 14.1.Барилга байгууламж дараах шаардлагыг хангасан байна:

14.1.1.зураг төслийн дагуу баригдсан байх;

14.1.2.барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангасан байх;

14.1.3.байгаль орчинд сөрөг нөлөөгүй байх;

14.1.4.зэргэлдээ орших барилга байгууламжийн ашиглалтын хэвийн нөхцөлийг алдагдуулахгүй байх.

төхөөрөмж хүлээн авах комисс томилон хүлээн авч, төсөл хөтөлбөрт хамрагдсан байгууллагад хүлээлгэн өгсөн байна.

Б.2.5.

Эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээнд дуусаагүй орхигдсон барилга байгууламж байхгүй боловч **“Дундговь аймгийн 800 суудалтай Төв халхын дуулалт жүжгийн театрын барилга”-ын ажил** зогсонги хэвээр байна. БСШУС-ын багцаас 10,543.7 сая төгрөгийн төсөвтэй, гүйцэтгэгч “Суурь ХХК”-тай 6,800.0 сая төгрөгөөр, 2012-2014 онд хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулсан.



2012 онд урьдчилгаа төлбөрийн баталгаагаар 2,040.0 сая төгрөг авсан, бодит хийгдсэн ажил 680.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Барилга угсралтын ажил 2012 онд эхэлж барилгын суурийн ажил болон баганын арматурчлалын ажил хийгдэн зогсож, 2019 онд газар шороо, цутгамал төмөр бетон бүтээцийн угсралтын ажил хийгдэж түүнээс хойш ажил хийгдээгүй байна. Барилгын баганаан суурийн бетон үйрч бутарсан, баганын арматурчлал зэвэрсэн ажлууд дээр 2015.05.01-ний өдөр “Реконстракшн” төвөөр дүгнэлт гаргуулж, захиалагч БСШУСЯ, Барилгын хөгжлийн төвтэй хамтран барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх шийдвэр гарган, албан тоотоор гүйцэтгэгч компанид хүргүүлсэн боловч одоог хүртэл барилга угсралтын ажил эхлээгүй байна. Захиалагч байгууллагаас гэрээ дүгнэж, гэрээг цуцлах хүсэлтийг 2014, 2016, 2017, 2018 онд албан бичгээр удаа дараа БСШУСЯ-ны сайдад хүргүүлсэн боловч хариу арга хэмжээ аваагүй байна. Мөн энэ ажил Соёлын яамны сайдын багцад хамааралтай болсон.

2014-2018, 2020, 2021 онд улсын төсөвт хөрөнгө тусгагдаагүй, 2019 онд 2,000.0 сая төгрөг, 2022 онд 1,000.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан байна.

Тус барилгын ажлын тендер шалгаруулалт, гэрээ байгуулах ажил нь анх БСШУ-ны яаман дээр зохион байгуулагдсан тул орон нутагт ажлын гүйцэтгэл, санхүүжилт, хэрэгжихгүй удаашралтай байгаа шалтгаан, түүний шийдвэрлэлтийн явцыг мэдэхэд төвөгтэй, албан ёсны мэдээлэл бага байгаа бөгөөд хэрхэн шийдвэрлэх талаар санал боловсруулахад хүндрэлтэй байна. *Эх сурвалж: УТХО-ын 2021 оны гүйцэтгэлийн аудитын тайлангаас.*



Б.3. Санхүүжилтийг хууль, журамд нийцүүлэн олгосон байна.

Б.3.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх эрх шилжиж ирсэн 9 төсөл арга хэмжээ нь 12,076.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй. Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар тайланд онд тус төсөл арга хэмжээнүүдийг санхүүжүүлэх 4,113.6 сая төгрөг батлагдсан байна. Тайлант онд гүйцэтгэлийг үндэслэн гэрээнд заасан хугацаанд 2,997.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Говь-Угтаал сумын Спорт залны барилгын гүйцэтгэгч Бум констракшн ХХК-нь зураг төсөв зохиогч компани зохиогчийн хяналтын гэрээ хийгээгүй, хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй учраас 500.0 сая төгрөгийн санхүүжилт авч чадаагүй байна. "Их соёл-Эх үндэс" төсөл хөтөлбөрийн 997.4 сая төгрөгийн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг Дундговь аймагт зохион байгуулсан бөгөөд 199.1 сая төгрөгийн тоног, төхөөрөмжийг Говь-Сүмбэр аймгийн Боловсрол шинжлэх ухааны газарт нийлүүлсэн байна.

Б.3.2 Нэмэлт санхүүжилтийн гэрээг эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээнүүдэд байгуулаагүй байна.

Төсөл арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлээр Сангийн яамнаас ирүүлдэг тул Дундговь аймгийн Төрийн сангийн дансанд үлдэгдэл байхгүй байна.

Б.4. Захиалагчийн хяналтыг 6 төсөл арга хэмжээнд 8 удаа гүйцэтгэсэн байна.

Б.4.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн барилга, байгууламжид Дундговь аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсээс тухай бүр захиалагчийн хяналтыг хийж, фото зургаар баримтжуулж, өгсөн үүрэг даалгаврынхаа хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байдал

Хүснэгт: №3

№	Төсөл, арга хэмжээний нэр	Захиалагчийн хяналт хийсэн тоо	Техник хяналтын зардал /сая төгрөгөөр/
1	Ноос хяргах байгууламж, тоног төхөөрөмж	1	0.8
2	Гудамж, талбайн тохижилт, ногоон байгууламж	1	1.2
3	Цэцэрлэгийн барилга, 150 ортой	1	4.0
4	Наадмын талбайн барилгын дуусгал	3	15.1
5	Спорт заалны барилга	1	4.1
6	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 2 км	1	8.4
	Нийт дүн	8	33.6

Захиалагчийн хяналтыг тайланд онд давхардсан тоогоор 8 удаа хяналт хийж, техник хяналтын зардалд 33.6 сая төгрөгийг зарцуулжээ.

Зохиогчийн хяналтыг 4 барилга байгууламжид хийж, зөвлөмж өгч ажилласан байна. Сайнцагаан сумын 2 дугаар цэцэрлэгийн 150 ортой барилгын буулгалтын ажил тайланд онд хийгдсэн учир зохиогчийн хяналт хийгдээгүй. Харин Говь-Угтаал сумын Спорт залны барилгын зураг төсөв зохиогч Алтай орд компани холбогдох боломжгүй болсон байна. Мэргэжлийн байгууллагуудаас Онцгой байдлын газраас галын аюулгүй байдлын талаар 2 барилга, байгууламжид хяналт хийж, зөвлөмж хүргүүлж ажилласан байна.

Б.4.2 Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт болох Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, гүйцэтгэлийн байдалд хяналт шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт өгөөгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1⁷ дахь заалтыг мөрдөж ажиллахгүй байгаатай холбоотой байна.



Б.5. Төсөл арга хэмжээг хүлээн авах комиссыг хууль журмын дагуу томилж, ашиглалтад ашиглалтад хүлээн авсан байна.

Б.5.1 Тайланд хугацаанд бүрэн хэрэгжиж дууссан 3 төсөл арга хэмжээ байна. Үүнээс барилга байгууламжийн ажил нэг, "Ижий говь", "Их соёл-Эх үндэс", "Шинэ хөдөө" төслийн эхний ээлжийн тоног, төхөөрөмжийг хүлээн авах комиссыг мэргэжлийн болон ашиглагч байгууллагын бүрэлдэхүүнтэй байгуулан, комиссын саналыг хурлын тэмдэглэлээр баталгаажуулж, дүгнэлт гарган хүлээн авсан байна.

Б.5.2. Наадмын талбайн дуусгал төсөл хөтөлбөрийг Дундговь аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2022 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн тушаалаар барилга, байгууламжийн ашиглалтад авах комисс томилсон байна. Тус комисс барилгын явцтай танилцан хугацаатай өгсөн үүрэг, даалгаврыг бүрэн хэрэгжсэний дараа буюу 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 20/2022 дугаар бүхий барилга, байгууламж ашиглалтад авах дүгнэлт үйлдэн хүлээн авсан

⁷ Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна "



байна. Аудитын явцад барилгын ажилтай танилцахад салхины улмаас үзэгчдийн суудлын дээвэр гол хэсгээрээ эвдэрсэн байдалтай байсан. Уг барилга, байгууламжийн ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа дуусаагүй тул Барилгын тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.6-т /Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн

ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна/ заасны дагуу гүйцэтгэгчийн зардлаар засвар хийлгэж, хүлээн авах шаардлагатай байна.

“Говь-Угтаал сумын Спорт залны барилга”, “Эрдэнэдалай сумын хатуу хучилттай авто замын ажил”-ууд 2019 онд эхэлсэн бөгөөд одоог хүртэл дуусаагүй байгаа нь гэрээг хангалтгүй биелүүлсэн байна.

Б.5.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тайланд онд бүрэн хэрэгжсэн “Ижий говь”, “Их соёл-Эх үндэс”, “Наадмын талбайн барилгын дуусгал” 3 төсөл арга хэмжээний 3,736.3 сая төгрөгийн, “Шинэ хөдөө” төслийн эхний ээлжийн 199.9 сая төгрөгийн нийт 3,936.2 сая төгрөгийн хөрөнгийг хүлээн авсан байна. “Их соёл-Эх үндэс” төсөл хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэгдсэн 798.3 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн 693.1 сая төгрөгийн тоног, төхөөрөмжийг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, соёл урлагийн газруудад хүлээлгэн өгснийг тус байгууллагуудад зохих бүртгэл дансанд тусган зориулалтын дагуу ашиглаж байна. Энэ төсөл арга хэмжээний үлдэгдэл 105.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжид хяналтын тооллого хийхэд 2.5 сая төгрөг 4 ширхэг тоног, төхөөрөмж анхан шатны баримтгүй олгосон. Мөн “Шинэ хөдөө” төслийн нийлүүлсэн 199.9 сая төгрөгийн тоног, төхөөрөмжийг хүлээн авсан боловч бүртгэл дансанд тусгаагүй тул зөрчлийг арилгах албан шаардлагыг тус тус хүргүүлсэн.

Хөрөнгийг бүртгэл, тайлан тусгаагүй зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4⁸, 14.4.2⁹ дахь заалтыг зөрчсөн байна.

Энэ нь хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалаалтад тавих хяналт суларч, хөрөнгө үрэгдэх, шамшигдах үр дагавартай байна.



БҮЛЭГ В. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хөгжлийн бодлоготой уялдуулж төлөвлөөгүй, хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй, зарим төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд гүйцэтгээгүй удаашралтай байна.

В.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хуульд нийцүүлэн төлөвлөөгүй байна.

В.1.1 Төсөл, арга хэмжээний 41.5 хувь нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдаагүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд нийт 1,557.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 21 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөж баталснаас аймгийн ИТХ-ын тогтоолоор 2 удаа өөрчлөлт оруулан, нийт дүнг 658.8 сая төгрөгөөр буюу 42.3 хувиар нэмэгдүүлэн 41 төсөл арга хэмжээ болгож баталсан байна. Өөрчлөлтийг хүснэгтээр харуулбал:

Батлагдсан төсөв /мянган төгрөг/

⁸ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ

⁹ бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;

№	Төсөл арга хэмжээний нэр	АИТХ-ын тогтоол 2021.12.03 №21	АИТХ-ын тогтоол 2022.04.13 №14	АИТХ-ын тогтоол 2022.05.26 №27	өөрчлөлт
	Шилжих ХО-ын дүн	135.0	135.0	135.0	-
	Барилга их засварын дүн	84.2	84.2	84.2	-
	Тоног төхөөрөмжийн дүн	79.4	325.9	278.6	199.2
	Төсөл арга хэмжээний дүн	536.8	854.4	875.4	338.6
	Шинэ хөрөнгө оруулалтын дүн	700.4	1,264.5	1,238.2	537.8
	Их засвар, арга хэмжээний дүн	722.2	722.2	843.2	121.0
	Нийт ОНТХО-ын дүн	1,557.6	2,121.7	2,216.4	658.8

Үүнээс их засварын ажлыг 16.8 хувиар, төсөл хөтөлбөрийг 63.1 хувиар, харин тоног төхөөрөмжийг 2.5 дахин нэмэгдүүлжээ.

ОНХО-ын бодлогын баримт бичигтэй нийцсэн байдал "Аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" "Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр" Алсын хараа 2050 монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого	Нийцсэн			Нийцээгүй		
	Тоо	Дүн	Хувь	Тоо	Дүн	Хувь
	30	1,243.2	56.1	11	973.2	43.9
	24	1,090.8	49.2	17	1,125.6	50.8
	18	1,064.6	48.0	23	1,151.8	52.0

Нийт төлөвлөсөн ТАХ-ний 973.2 сая төгрөгийн 11 ТАХ нь "Аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-тэй, 1,125.6 сая төгрөгийн 17 ТАХ нь "Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртэй, 1,151.8 сая төгрөгийн 23 ТАХ нь Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой тус тус уялдаагүй байна. Энэ нь "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянах тайлагнах журам"-ын 3.1.4¹⁰-д заасныг зөрчиж байна.


Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг урт болон дунд хугацааны

бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан төлөвлөхгүй байгаа нь өмнөх онуудад хийсэн аудитаас өгсөн зөвлөмж, хугацаатай албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс шалтгаалж дахин давтан гарсаар байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөлтийг графикаар харуулбал:

¹⁰ /Төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэл төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг ирүүлэхдээ дараах зарчмыг баримталж холбогдох тайлан материалыг хавсарна. Үүнд:

- Бодлогын баримт бичигт тусгагдсан байдал;
- Тухайн жилийн хөрөнгө оруулалтын бодлогын чиглэл болон үндсэн чиглэлтэй нийцэж буй байдал;
- Хэрэгцээ шаардлага үндэслэл;
- Мэргэжлийн байгууллагын дүгнэлт;
- Төслийн зардлыг бүрэн зөв тооцсон эсэх;
- Санхүүжилтийн эх үүсвэрийн төрөл



Графикаас харахад орон нутгийн төсвийн нийт хөрөнгө оруулалтын 875.4 сая төгрөг буюу 39.5 хувийг төсөл арга хэмжээнд төлөвлөсөн нь хамгийн их хувийг эзэлж байна. Үүнээс 329.0 сая төгрөг буюу 37.6 хувь нь аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл, тэмцээн уралдаан, “наадам” эвент арга хэмжээ зохион байгуулах зэрэг хөрөнгийн бус нэг удаагийн шинж чанартай арга хэмжээнд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24¹¹-д заасныг зөрчсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь төсвийн төслийн саналд хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөхдөө судалгаа хийж, нэн тэргүүний чухал ач холбогдолтой төслүүдийг тодорхойлон эрэмбэлж, жагсаалт гарган баримтжуулаагүй байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянах” журмын 2.1.2.2¹² заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Төсвийг урт, дунд хугацааны бодлоготой уялдуулаагүй, ирээдүйд бий болгох үр ашиг, хэрэгцээ шаардлагыг тооцож эрэмбэлэхгүй төлөвлөж байгаа нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулах, зөрчил дахин давтан гарах, хөгжлийн бодлогын уялдаа холбоо алдагдах, хууль тогтоомж зөрчигдөх, ажлын хариуцлага сулрах сөрөг үр дагавартай байна. Дээрх зөрчлийг давтан гаргуулахгүй байхаар аудитаас зөвлөмж хүргүүллээ.

Иймд орон нутгийн хэрэгцээ шаардлагын суурь судалгааг жил бүр хийж аймгийн урт хугацааны хөгжлийн бодлого, аймаг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигтэй уялдуулан, ирээдүйд үр өгөөжөө өгөх, орон нутгийн хөгжилд тодорхой дэмжлэг болохуйц төсөл арга хэмжээнд төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөж байх шаардлагатай байна.

В.1.2. Төсвийн тухай болон төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөсөн ч тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийн босго үнэд багтаан төсөвт өртгийг хувааж төлөвлөн, баталсан байна.

Тайлант онд орон нутгийн төсөвт хөрөнгө оруулалтыг Төсвийн тухай хуулийн 29.4-д нийцүүлэн хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан төсөл, арга хэмжээг тусгасан байна. Мөн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт багтсан төсөл, арга хэмжээний нийт өртөг, эхлэх болон дуусах хугацаа, төсвийн жилд зарцуулах хэмжээг төсөл нэг бүрээр төлөвлөжээ.

Хөрөнгө оруулалтын батлагдсан төлөвлөгөөнөөс тодотголоор:

- Алслагдсан сумдын иргэдэд явуулын амбулаторийн үйлчилгээ үзүүлэх төслийг 2.8 сая төгрөгөөр;
- Хөдлөх хөрөнгийн их засвар, үйлчилгээг 59.0 мянган төгрөгөөр тус тус бууруулсан нь Төсвийн тухай хуулийн 29.3.6¹³-д заасныг зөрчсөн байна. Гэтэл хөдлөх хөрөнгийн их засвар, үйлчилгээний зардлын дүнг тодотголоор 48.3 хувиар бууруулсаар байхад гүйцэтгэлээр 4.1

¹¹ "хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

¹² төслийн саналд энэ журамд заасны дагуу судалгаа хийж, эрэмбэлэн улсын төсвөөр хэрэгжүүлэх нэн тэргүүний ач холбогдолтой төслүүдийг тодорхойлох, жагсаалт гаргах;

¹³ / тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх;

сая төгрөгөөр хэмнэгдсэн нь тус арга хэмжээний хувьд өндөр буюу бодитой төлөвлөж чадаагүйг харуулж байна.

Тайлант онд цэнгэлдэх хүрээлэнг дуусгах 160.0 сая төгрөгийн ажлыг төлөвлөхдөө хугацаа бага гэсэн шалтгаанаар 20.0 сая төгрөгийн 8 хэсэг ажил болгон хувааж ИТХ-аар батлуулж тус бүрийг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлжээ. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1¹⁴, 8.1.1¹⁵, 8.7¹⁶ 8.7.1¹⁷, 8.5¹⁸, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнийг тус тус зөрчсөн байна. Энэ зөрчлийг дахин давтан гаргуулахгүй байхаар хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

Мөн Улс төрийн хэлмэгдэгчдийн дурсгалын талбай байгуулах ажилд 10.0 сая төгрөгийг төлөвлөж зарцуулсан нь цаг хугацааны хувьд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3.1¹⁹-д хамаарахгүй ч орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулахааргүй, хөрөнгө оруулалтын шинж чанаргүй, хэрэгцээ шаардлага багатай, иргэд олон нийт, ирээдүй хойч үед мэдлэг, мэдээлэл, сургамж өгч чадахааргүй, нийгмийн ач холбогдолгүй үрэлгэн зардал болсон байна.

Иймд хөрөнгө оруулалтыг хууль тогтоомжид нийцүүлэн, үр ашигтай төсөл арга хэмжээг төлөвлөж байх нь зүйтэй.

В.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт үр дүнтэй ч шугамын өргөтгөлийн ажил удаашралтай, гэрээний хугацаандаа хэрэгжээгүй байна.

В.2.1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар тайлант онд нийт 14 ТАХ-ний худалдан авах ажиллагаанд тендер шалгаруулалт зохион байгуулахаас 3 ТАХ-нд нээлттэй тендер шалгаруулалтын арга, 10 ТАХ-ний худалдан авах ажиллагаанд харьцуулалтын арга хэрэглэж тендерийн 92.9 хувь нь амжилттай болсон, багийн төвийн конторын барилга барих ажлын тендерийг 3 удаа зарлан, амжилтгүй болж дараа онд шилжсэн байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн, тендер зарласан 13 ажлаас Сайхан-Овоо сумын Соёлын төвийн их засварын ажлыг суманд нь эрх шилжүүлж, 12 ажилд аймгийн ЗДТГ захиалагчаар ажиллажээ. Аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар үнэлгээний хороог тухай бүрд нь байгуулж, тендерийн жишиг баримт бичиг, ирүүлэх шаардлагатай бүх мэдээлэл, тендер шалгаруулах шалгуур үзүүлэлт, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт зэргийг бэлтгэж, худалдан авах ажиллагааны цахим системд нийтэд зарлан мэдээлжээ.

Захиалагчийн байгуулсан үнэлгээний хороо нь ирүүлсэн тендерийн баримттай танилцан, үнэлгээ хийсэн, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэл, саналын хувь зэргийг хурлын тэмдэглэлээр баримтжуулсан байна.

Үнэлгээний хорооны хурлын шийдвэрийг үндэслэн тендерт шалгарсан гүйцэтгэгчид Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29.1-д заасан хугацаанд гэрээ байгуулах тухай, харин бусад оролцогчдод татгалзсан мэдэгдлийг аймгийн ЗДТГ-ын албан бичгээр тухай бүр мэдэгдэл хүргэсэн байна.

¹⁴ /Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр дараах босго үнийг тогтооно

¹⁵ /харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар/

¹⁶ /Захиалагч энэ хуулийн 8.6-д зааснаар тендер шалгаруулалтыг багцад хувааж явуулахдаа дараах шаардлагыг хангана/

¹⁷ /тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох

¹⁸ /Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно

¹⁹ /хөшөө, дурсгал, орон нутгийн угтах, үдэх хаалга барьж байгуулах/;

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулж ажилласан ч Эрдэнэдалай сумын Соёлын төвийн тайзны хөшиг нийлүүлэх ажлын гүйцэтгэгчид эрх олгох шийдвэрийг гаргаж баримтжуулаагүй байна.

Нийт зохион байгуулсан худалдан авах ажиллагаанаас «Хамгийн сайн» үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээ байгуулахаас татгалзсан, эсхүл түүнд олгосон гэрээ байгуулах эрхийг захиалагч хүчингүй болгосон, захиалагчаас үл хамаарах шалтгаанаар тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулах боломжгүй болсон асуудлууд гараагүй байна.

Харин оролцогчдоос ирүүлсэн тендер шаардлага хангаагүйгээс “Эрдэнэдалай сумын Соёлын төвийн тайзны хөшиг нийлүүлэх” болон “Бохир усны 458-р худгаас 416-р худаг хүртэл шугамын өргөтгөл”-ийн ажлуудын тендер 2-3 удаа дахин зарлагдсан байна.

Хамгийн сайн үнэлэгдсэн тендер болон захиалагчийн техникийн шаардлагыг хангаж үнийн санал ирүүлсэн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд гэрээний үнэ, төлбөр хийх нөхцөл, хэлбэр, урьдчилгаа төлбөрийн баталгааны дүн, захиалагчийн хяналт болон бусад нөхцөл, гүйцэтгэлийн баталгаа шаардах дүн, хэлбэр, бараа нийлүүлэх, ажил, үйлчилгээ гүйцэтгэх хуваарь зэргийг тусган баталгаажуулж ажиллажээ.

Тайлант онд гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчлөх, гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэх, журмыг зөрчиж гэрээ байгуулах, тендер шалгаруулалтын эцсийн дүнд илт нөлөөлсөн зэрэг ноцтой асуудлууд гараагүй байна.

В.2.2. Зарим төсөл. арга хэмжээг гэрээний хугацаанд багтаан гүйцэтгээгүй байна.



Аймгийн ИТХ-ын 2022 оны 05 дугаар сарын 26 –ны өдрийн 27 дугаар тогтоолоор нэмэгдүүлэн баталсан 41 төсөл арга хэмжээнээс:

- Багийн ахмадын төв /40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/ барих ажил тайлант онд 3 удаа тендер зарласан боловч амжилтгүй болсон.
- Сайнцагаан сумын төвд зөвшөөрөлгүй газар ашигласан иргэн, аж ахуйн нэгжийн газар чөлөөлөх зардал гаргах шаардлагагүй болсон шалтгаанаар тус тус хийгдээгүй байна.

Харин Цэргийн ангийн хөгжмийн салаанд шаардлагатай хөгжим хэрэгсэл нийлүүлэх ажлын 19.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон боловч бүрэн нийлүүлэгдээгүйгээс хүлээж аваагүй, жилийн эцэст авлагаар тайлагнасан ба 2023 оны 3 дугаар сард хүлээж авчээ.

Хил хаасантай холбоотой бараа материалын нийлүүлэлт саатсан, төмөр замын тээврийн зөвшөөрөл удааширсан, цемент хомсодсон зэрэг шалтгаанаар хугацааг 1-4 сараар сунган гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан дараах ТАХ-үүд байна. Үүнээс:

- Аймгийн ИТХ-ын ажлын албаны хэрэгцээт тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээг 2 удаа нийт 4 сараар;
- Дундговь буудлагын спортын холбооны албан хэрэгцээнд электрон бай нийлүүлэх гэрээг 3 сараар;
- Жүдогийн олон улсын стандартад нийцсэн дэвжээ худалдан авах ажлын гэрээг 1 сараар;
- Сайхан-Овоо сумын Соёлын төвийн их засвар 3 сараар тус тус сунгаж хугацаанд нь хүлээлгэн өгсөн.

Харин Мэргэжлийн хяналтын газарт Кьелдаль багаж болон Пестицидийн үлдэгдэл тодорхойлох багаж нийлүүлэх гэрээг 1 сараар сунгаж 2022 оны 04 дүгээр сарын 01-ний дотор нийлүүлэхээс 04 дүгээр сарын 15 нийлүүлж хугацаа хоцроосон байна.

Мөн бохир усны 458-р худгаас 416-р худаг хүртэл шугамын өргөтгөлийн ажлын тендерийг 3 удаа зарлан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажлын гүйцэтгэх гэрээгээр 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдөр ажлыг эхэлж, 10 дугаар сарын 25-ны өдөр дуусган ашиглалтад оруулахаар заасан ч хугацаа сунгаагүй, тодорхойгүй шалтгаанаар өнөөг хүртэл дуусаагүй удаашралтай байгаа тул зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

Хөтөлбөр, арга хэмжээ хөрөнгө оруулалтын хүрээнд “Хүний нөөцийг хөгжүүлэх дэд” хөтөлбөр баталж 300.0 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 297.1 сая төгрөгийг нэгдсэн сургалт, эрүүл мэндийн дэмжлэг, орон сууцны дэмжлэг, сургалтын төлбөр зэрэгт зарцуулжээ. Сургалтын төлбөрийн дэмжлэг олгохдоо суралцагчидтай гуравласан гэрээ байгуулж баримтжуулсан байна. Цаашид боловсон хүчнийг чадавхжуулах, орон нутагт нэн шаардлагатай нарийн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, хүний нөөцөд хөрөнгө оруулалт хийхдээ хэрэгцээ шаардлагыг чухалчлах, сонголт хийж байгаа шалгуурыг олон нийтэд ил тод болгох, бүх салбарыг хамарсан судалгааг үндэслэн шийдвэрлэж байх нь зүйтэй.

В.2.3. Санхүүжилтийг хууль, журам, гэрээнд нийцүүлэн олгосон байна.



Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл арга хэмжээг хийж гүйцэтгүүлэхээр нийт 2,042.0 сая төгрөгийн гэрээ байгуулжээ. Үүнээс гүйцэтгэлээр тайлант онд 1,948.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь 95.4 хувьтай, 93.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Санхүүжилтийн гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

№	ХАА-ны төрөл	Төсөвт өртөг	Гэрээний үнэ	Гүйцэтгэлээрх үнэ	Санхүүжилтийн гүйцэтгэлийн хувь
1	Тендер зарлаж гүйцэтгүүлсэн ТАХ	1,099.3	1,018.6	926.7	91.0%
2	Шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн ТАХ	1,117.1	1,023.4	1,021.9	99.8%
	дүн	2,216.4	2,042.0	1,948.6	95.4%

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар тайлант онд зохион байгуулсан тендерт шалгарсан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр нийт 1,018.6 сая төгрөгийн санхүүжилт олгохоос тайлант онд 926.7 сая төгрөгийг олгосон 91.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд 83.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бохир усны 458-р худгаас 416-р худаг хүртэл шугамын өргөтгөлийн ажлын тендерт Дундговь-Ус ОНӨААТҮГ шалгаран, ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан ба тайлант онд ажлын гүйцэтгэл 50 хувьд хүрээгүй тул гэрээний дагуу санхүүжилт олгогдоогүйтэй холбоотой байна.

Мөн Сайхан-Овоо сумын Соёлын төвийн их засварын ажлын санхүүжилт 8.2 сая төгрөгөөр дутуу байгаа нь 4.0 сая төгрөгийн засварын ажлын зураг төсвийн санхүүжилт өмнөх онд олгогдсон, 4.2 сая төгрөг хэмнэгдсэн, БТСГ-ын барилгын дээврийн засварын ажлын санхүүжилт 0.4 сая төгрөгөөр дутуу олгогдсонтой тус тус холбоотой байна.

Эдгээр нь бодит хэмнэлт биш бөгөөд үлдэгдлийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.3²⁰-д заасны дагуу зарцуулаагүй байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 1,117.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 төсөл арга хэмжээг гүйцэтгүүлэхээр 1,023.4 сая төгрөгийн шууд гэрээ байгуулж 1,021.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон 99.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь техникийн нөхцөл авах ажил 1.5 сая төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

²⁰ / хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх;

Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнүүдэд ажлын гүйцэтгэлийн хэдэн хувьд санхүүжилтийг олгох талаар тодорхой тусгаж, мөрдөж ажилласан, “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын 2.3.2.4-т заасны дагуу засварын ажил, тоног төхөөрөмж, төсөл арга хэмжээг ашиглалтад хүлээн авах комиссын акт, гүйцэтгэгчийн эцсийн санхүүжилт хүссэн албан бичиг, захиалагчийн тооцоог тус тус үндэслэн санхүүжилтийг олгож баримтжуулсан байна.

В.2.4. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Тайлант онд орон нутгийн төсвөөс нийт 2,216.6 сая төгрөгийн 41 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталснаас:

- Багийн ахмадын төв /40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/ тендер 3 удаа зарлаад амжилтгүй болсон тул дараа онд шилжүүлсэн;
- Сайнцагаан сумын төвд зөвшөөрөлгүй газар ашигласан иргэн, аж ахуйн нэгжийн газар чөлөөлөх /10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/ шаардлагагүй болсноос тус тус хийгдээгүй байна.

Тайлант онд гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан нийт 2,015.3 сая төгрөгийн 39 төсөл арга хэмжээнээс тайлант онд бүрэн хийгдээгүй он дамжсан дараах ажлууд байна. Үүнд:

- Цэргийн ангийн хөгжмийн салаанд шаардлагатай хөгжим хэрэгсэл нийлүүлэх /19.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/;
- Бохир усны 458-р худгаас 416-р худаг хүртэл шугамын өргөтгөлийн ажил /83.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/;

Бусад бүрэн хэрэгжсэн 37 төсөл арга хэмжээнээс:

- “Бүрдийн уянга” хүүхдийн зуслангийн дээврийн засвар;
- БТСГ-ын барилгын дээврийн засвар;
- ТХДЖТеатрын барилгын пасадны засварын ажлууд захиалагч болон зохиогчийн хяналтыг хийсэн.

Харин Сайхан-Овоо сумын Соёлын төвийн их засварын ажилд захиалагч хяналтыг хийсэн зохиогчийн хяналт хийгдээгүй байна.

Үлдсэн 33 төсөл арга хэмжээнээс 10 ажил буюу аймгийн ИТХ-ын ажлын албаны хэрэгцээт тоног төхөөрөмж, Говь-Угтаал сумын эрүүл мэндийн төвийн шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх, Цэнгэлдэх хүрээлэнгийн дуусгалтын 8 ажлыг хүлээн авахдаа гэрээ дүгнэсэн акт үйлдэж баримтжуулсан нь нийт ажлын 30.3 хувийг эзэлж байна.

Энэ нь “төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.30 /Төслийн эцсийн санхүүжилт ирүүлэхэд гэрээг дүгнэсэн байх ёстой бөгөөд хавсралт №12-т заасан “Гэрээ дүгнэх маягт”-ыг үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана./ заалтыг зөрчсөн байна.

Иймд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг гүйцэтгэгчээс хүлээн авахдаа гэрээний үүргийн биелэлтийг тооцож, акт үйлдэн баримтжуулж хэвших нь зүйтэй.

Мөн үл хөдлөх хөрөнгийн засварын ажлаас авто тээврийн хэрэгслийн засварын нийт 6.7 сая төгрөгийн 2 ажлыг гэрээ, нэхэмжлэх зэрэг анхан шатны баримтгүйгээр санхүүжилтийг олгожээ. Энэ нь “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах,

тайлагнах журам”-ын 4.1.30²¹, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1²², 13.7²³ заалтуудыг тус тус зөрчсөн байна. Баримтыг бүрдүүлж аудитын явцад зөрчлийг арилгууллаа.

Цаашид анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэх, хүчин төгөлдөр анхан шатны баримтыг үндэслэн санхүүжилтийг олгож, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах нь зүйтэй.

В.2.5. Зарим төсөл, арга хэмжээг хүлээн авч ашиглалтад оруулахдаа акт үйлдээгүй, гэрээний үүргийн биелэлтийг тооцож баримтжуулаагүй байна.



Тайлант онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн засварын ажлуудад захиалагчийн хяналтын тайлан, нэгдсэн дүгнэлт, зураг төсөл зохиогчийн хяналтын тайлан, нэгдсэн дүгнэлтийг бичиж баримтжуулсан байна.

Говь-Угтаал сумын Эрүүл мэндийн төвийн шаардлагатай тоног төхөөрөмжийг угсарсан акт, тоног төхөөрөмжийг зааврын дагуу суурилуулсан эсэхэд хийсэн туршилтын тэмдэглэл, хүлээлгэн өгсөн актыг үйлдэж баримтжуулжээ.

Гүйцэтгэгч нь засварын ажил, тоног төхөөрөмж төсөл арга хэмжээг хүлээлгэн өгөхөд бэлэн болсон тухай мэдэгдлийг албан бичгээр ирүүлсэн тухай бүрд захиалагч хүлээн авах ажлын хэсгийг тушаалаар томилж гэрээг дүгнэн акт үйлдэж баримтжуулж ажиллажээ.

Харин “Аялал жуулчлалын мэдээллийн төв”, “Цэнгэлдэх хүрээлэнгийн засварын 8 ажил”-ыг хүлээн авах ажлын хэсгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хамт хүлээн авсан байна.

Засварын ажил, тоног төхөөрөмж, төсөл арга хэмжээг хүлээн авсны дараа хяналтын хуудсыг бичиж ХБТХОХ-ийн дарга, мэргэжилтэн нар баталгаажуулснаар хяналтын хуудсыг үндэслэн санхүүжилтийн тооцоог хийж ажиллажээ.

Гүйцэтгэлээр нийт 1,948.6 сая төгрөгөөс 861.5 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагын хөрөнгийн дансанд орлого авч, санхүүгийн тайланд тусгасан, нэг удаагийн шинж чанартай 1,087.1 сая төгрөгийг зардлаар тайлагнасан байна. Хөрөнгийн дансанд бүртгэсэн засвар, тоног төхөөрөмжүүд нь зориулалтын дагуу бүрэн ашиглагдаж байна.

21 / Төслийн эцсийн санхүүжилт ирүүлэхэд гэрээг дүгнэсэн байх ёстой бөгөөд хавсралт №12-т заасан “Гэрээ дүгнэх маягт”-ыг үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана;

22 / Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно;

23 / Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно;



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн зарим төсөл, арга хэмжээ үр дүн багатай байна.

Бүлэг А.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хууль, хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлж төлөвлөсөн байна.

- ✓ Төсөл арга хэмжээ нь Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдаагүй байна;
- ✓ Төсөл арга хэмжээний эдийн засгийн үр ашгийг тооцож төлөвлөөгүй байна.

Бүлэг Б. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хууль журмын дагуу хэрэгжүүлж байна.

- ✓ Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна;
- ✓ Төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой хугацаанд эрхийг шилжүүлсэн боловч зарим ТАХ-ний тендер шалгаруулалт зохион байгуулахдаа хугацаа алдсан байна;
- ✓ “Эрдэнэдалай сумын хатуу хучилттай 2км авто зам”, “Говь-Угтаал сумын Спорт залны барилга”-ын гүйцэтгэл удааширалтай байна;
- ✓ Ашиглалтад орсон 199.9 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл, тайланд тусгаагүй байна;
- ✓ Санхүүжилтийг хууль, журамд нийцүүлэн олгосон байна;
- ✓ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж барилга, байгууламжид захиалагчийн хяналтыг фото зургаар баримтжуулж, өгсөн үүрэг даалгаврынхаа хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна;
- ✓ Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт болох Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, гүйцэтгэлийн байдалд хяналт шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт өгөөгүй байна.

Бүлэг В. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хөгжлийн бодлоготой уялдуулж төлөвлөөгүй, хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй, зарим төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд гүйцэтгээгүй удааширалтай байна.

- ✓ ОНХО-ыг төсвийн тухай болон төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөсөн ч ТАХ-ний 41.5 хувь нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдаагүй, тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийн босго үнэд багтаан төсөвт өртгийг хувааж төлөвлөн, баталсан байна.
- ✓ Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж санхүүжилтийг хууль, журам, гэрээнд нийцүүлэн олгосон ч хэрэгжилтэд тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс зарим төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд багтаан гүйцэтгээгүй, гэрээний үүргийн биелэлтийг тооцож баримтжуулаагүй байна.



Зөвлөмж

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

1. Төсөл арга хэмжээг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-тай аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, баримт бичигтэй уялдуулан жил бүрийн хөрөнгө оруулалтыг төлөвлөж байх;
2. Хөрөнгө оруулалт бага хийгдэж байгаа салбарын хэрэгцээ шаардлагыг судалж аймгийн хүн ам, нийгэм, эдийн засгийн үзүүлэлт болон тухайн салбарын үндсэн үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж, барилга, байгууламжийн чанар, насжилт, хүчин чадал зэргийг тооцон үзэж, хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөх;
3. Наадмын талбайн дуусгал ажлын гэрээт хугацаанд үүссэн эвдрэлийн шалтгааныг тогтоож, гүйцэтгэгч компаниар засварын хийлгэж, чанарын хяналт тавьж барилга байгууламжийг хэвийн үйл ажиллагаанд оруулах ажлыг зохион байгуулах;
4. Орон нутгийн хэрэгцээ шаардлагын суурь судалгааг жил бүр хийж дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан, ирээдүйд үр өгөөжөө өгөх, орон нутгийн хөгжилд тодорхой дэмжлэг болохуйц төсөл арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн төсвийн хөрөнгө оруулалтад төлөвлөж байх;
5. Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүдийг хүлээн авсан акт, гэрээний үүргийн биелэлтийг дүгнэх ажлыг бүрэн хийж хэвших, хүчин төгөлдөр анхан шатны баримтыг үндэслэн санхүүжилтийг олгож, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах;

Санхүүгийн хяналт, дотоод аудит албанд:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, гүйцэтгэлийн байдалд хяналт шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт өгч удирдлагын шийдвэр гаргалтад зөвлөн тусалж байх;

Орон нутгийн өмчийн газарт:

1. ХАА-нд мөрдөх хугацааг төлөвлөхдөө ТАХ-ний цар хүрээ, онцлог шинж чанар, худалдан авах ажиллагаанд мөрдөх журам, санхүүжилтийн хуваарь зэргийг харгалзан үзэж, төлөвлөгөөний дагуу ХАА-г зохион байгуулах;



Шалгагдагч байгууллагын санал тайлбар

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасны дагуу аудитын тайлангийн төслийг аймгийн Засаг даргад танилцуулж санал тайлбарыг авлаа.



2023. 04. 20 № 01/544
танай _____ -ны № _____ -т

Хариу тайлбар хүргүүлэх тухай

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Т.Батсайхан
Сүхбаатар хэрэгсэл
11/20

“Улсын болон орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тус аудитаар илэрсэн алдаа, зөрчил буюу албан шаардлагад дараах тайлбартай байна.

1. “Шинэ хөдөө” төслийн хүрээнд нийлүүлэх тоног төхөөрөмжийг явуулын ноос хяргах 5 багц болгон 5 сумданд хувиарлахаар төлөвлөсөн. Гэвч 2023 оны улсын төсөвт тухайн онд санхүүжих дүн нь 200,000 (хоёр зуун сая) төгрөг болж батлагдсанаар 2022 онд сумдад хувиарлах боломжгүй болсон тул 2023 онд бүх тоног төхөөрөмжийг хүлээн авч сумдад албан ёсоор хүлээлгэн өгөхөөр болсон. Иймд ямар нэг албан байгууллагын бүртгэлд бүргүүлээгүй хадгалж байсан болно.

2. Наадмын талбайн засварын нийт төсөвт өртөг нь 300,000 (гурван зуун сая) гаран сая төгрөгийн ажлыг зөвхөн материалын зардлаар буюу 160,000 (нэг зуун гаран сая) төгрөгийн санхүүжилтээр орон нутгийн барилгын компаниудаар нийгмийн хариуцлагын хүрээн хийж гүйцэтгүүлсэн болно.

3. Нэгдсэн эмнэлэгийн бохирын шугамын өргөтлийн ажил нь 2022 онд 3 удаа тендер зарлаж гүйцэтгэгчээр “Дундговь-Ус” ОНӨҮГ шалгарсан. Тус ажлын гэрээ тухайн онд оройтож байгуулагдсан бөгөөд ажлын онцлогоос шалтгаалан гадаа дулаарч газар гэхэд үед ажил эхлэх тайлбартай гэрээний хугацаа сунгах хүсэлт ирсэн байгаа билээ.

Иймд дээрх албан шаардлагуудыг тус тайланд өөрчилж өгөхийг хүсье.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ

4823130351



Аудитын байгууллагын тайлбар

Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчаас ирүүлсэн тайлбарт хариу өгөх Аудитын газрын тайлбар

Тайлбар 1	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 –д /Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ./, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д /Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ/, 14.4.2.-т /бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;/, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолын хавсралтын 5.3.3-т /Захиалагч байгууллага нь барилга байгууламж болон их засварын ажлын хувьд уг ажлыг дуусах хүртэл хугацаанд, тоног төхөөрөмжийн хувьд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр бусад эргэлтийн хөрөнгөөр тус тус бүртгэн санхүүгийн тайландаа тусгана/ заасныг тус тус зөрчсөн тул албан шаардлагыг өөрчлөх боломжгүй.
Тайлбар 2	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах /ТБОНӨХБАҮХА/ тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д /Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална./, 8 дугаар зүйлийн 8.6-д /Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар нь хэд хэдэн багцад хувааж тендер шалгаруулалт явуулж болно./, 8.7.1.-д /тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох;/ заасныг тус тус зөрчсөн тул албан шаардлагыг өөрчлөх боломжгүй.
Тайлбар 3	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах /ТБОНӨХБАҮХА/ тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6-д /гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах;/, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.1.2.6 /төслийн хэрэгжилтийг хууль журмын хүрээнд зохион байгуулж, хангах, хяналт тавих/ заасныг тус тус зөрчсөн тул албан шаардлагыг өөрчлөх боломжгүй.

2022 ОНД УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ УЯЛДСАН БАЙДАЛ

Д/д	Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Алсын хараа-2050	2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	2022 оны хөгжлийн төлөвлөгөө
1	Хот, суурин газрын ус хангамжийн эх үүсвэрийн нөөц тогтоох судалгаа, хайгуул /Говь-Алтай, Төгрөг сум, Дундговь, Эрдэнэдалай сум, Дорноговь, Дэлгэрэх сум, Өмнөговь, Сэврэй сум/	3,000.0	240.0	Үгүй	Үгүй	Үгүй
2	Ноос хяргах байгууламж, тоног төхөөрөмж /Дундговь, Хулд сум/	250.0	50.0	4.2.2	4.1.1.3	Үгүй
3	“Ижий говь” төсөл хөтөлбөр /Дундговь/	1,000.0	1,000.0	8.2.3	8.2.1.2	Үгүй
4	Гудамж, талбайн тохижилт, ногоон байгууламж /Дундговь/	1,000.0	100.0	6.4.3	6.2.2.1	Үгүй
5	Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл /Дундговь/	1,000.0	200.0	8.3.1	8.3.1.3	Тийм
6	Ахмадын өргөөний барилга /Дундговь, Сайнцагаан сум/	1,160.0	339.4	3.5.10	3.4.2.3	Тийм
7	Сумын төвийн усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж /Дундговь, Сайхан-Овоо сум/	3,250.0	2,214.4	Үгүй	Үгүй	Тийм
8	“Их соёл-Эх үндэс” төсөл хөтөлбөр /Дундговь, Говьсүмбэр/	1,000.0	1,000.0	2.1.20	2.1.3.1	Үгүй
9	Сургууль, цэцэрлэгийн тоног төхөөрөмж /Дундговь/	700.0	100.0	2.1.12	Үгүй	Тийм
10	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах тоног төхөөрөмж /Дундговь/	900.0	100.0	2.2.27	2.2.2.2	Тийм
11	Усан бассейн бүхий спорт цогцолборын барилга /Дундговь, Сайнцагаан сум/	13,000.0	1,600.0	3.5.5	3.4.1.4	Тийм
12	Сургуулийн барилга, 640 суудал, спорт заал /Дундговь, Сайнцагаан сум/	9,548.3	400.0	2.1.12	2.1.2.1	Тийм
13	Сургуулийн дотуур байрны барилга, 80 ор /Дундговь, Говь-Угтаал сум/	1,600.0	160.0	2.1.19	2.1.2.1	Тийм

14	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дундговь, Дэлгэрцогт сум, 2 дугаар цэцэрлэг/	2,882.0	160.0	2.1.12	2.1.1.1	Тийм
15	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дундговь, Сайнцагаан сум, 2 дугаар цэцэрлэг/	3,026.0	239.6	2.1.12	2.1.1.1	Тийм
16	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дундговь, Эрдэнэдалай сум, 2 дугаар цэцэрлэг /	2,094.0	209.4	2.1.12	2.1.1.1	Тийм
17	Наадмын талбайн барилгын дуусгал /Дундговь, Сайнцагаан сум/	2,000.0	469.1	3.5.10	3.4.1.3	Үгүй
18	Спорт заалны барилга /Дундговь, Говь-Угтаал сум/	1,000.0	500.0	3.5.10	Үгүй	Тийм
19	Дотуур байрны барилга, 80 ор /Дундговь, Луус сум/	973.0	259.9	2.1.19	2.1.2.1	Тийм
20	Сургуулийн барилга, 960 суудал /Дундговь, Сайнцагаан сум, Говийн ирээдүй цогцолбор/	5,496.4	2,748.2	2.1.12	2.1.2.1	Тийм
21	Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Дундговь, Сайхан-Овоо сум/	4,494.5	2,946.3	2.1.12	2.1.2.1	Тийм
22	Сургуулийн дотуур байрны барилга /Дундговь, Гурвансайхан сум/	1,040.0	162.0	2.1.19	2.1.2.1	Тийм
23	Сургуулийн спорт заалны барилга /Дундговь, Адаацаг сум/	2,022.2	200.0	2.1.19	Үгүй	Үгүй
24	"Төв халх" дуулалт жүжгийн театр /Дундговь, Сайнцагаан сум/	10,543.7	200.0	1.1.19	1.1.1.1	Тийм
25	Соёлын төвийн барилга /Дундговь, Дэлгэрцогт сум/	1,237.2	237.2	1.1.19	1.1.1.4	Тийм
26	Соёлын төвийн барилга, соёлын заал, 400 суудал, номын сан, 45 суудал /Дундговь, Эрдэнэдалай сум/	2,332.0	532.0	1.1.19	1.1.1.4	Тийм
27	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 2 км /Дундговь, Эрдэнэдалай сум/	1,800.0	554.9	Үгүй	Үгүй	Тийм
28	Сум дундын эмнэлгийн барилга /Дундговь, Эрдэнэдалай сум/	2,200.0	700.0	2.2.27	Үгүй	Үгүй

Хавсралт 2

ЭРХ ШИЛЖИН ИРСЭН ТӨСӨЛ АРГА, ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ /ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ХУГАЦАА/
СУДАЛГАА №1

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байришил	Хугацаа		Төсөвт өртөг / сая төгрөг /	Тухайн онд санхүүжих дүн / сая төг /	ТЕЗ-ийн нэр	Эрх шилжүүлсэн шийдвэр, огноо, дугаар		Үнэлгээний хорооны худалдан авах ажиллагаанд мөрдсөн хугацаа			
		Эхлэх	Дуусах				ТЕЗ-ийн шийдвэр	ТЕЗ-ийн огноо, дугаар	Үнэлгээний хороо			
									Байгуулах арг төлөвлөсөн огноо	Байгуулсан огноо	Үүнээс, хэтэрсэн хоног	Эрх шилжсэн хугацаанаас хойш байгуулсан
А		1	2	3	4	5	6	7	8	9	10=9-8	11=9-7
1	Ноос хяргах байгууламж, тоног төхөөрөмж /Дундговь, Хулд сум/	2022.04.19	2022.06.30	250.0	50.0	АЗД	ЗГ-ын №359 тогтоол	12/1/2021	1/6/2022	2/22/2022	47	83
2	“Ижий говь” төсөл хөтөлбөр /Дундговь/	2022.04.18	2022.06.15	1,000.0	1,000.0	АЗД	ЗГ-ын №359 тогтоол	12/1/2021	1/6/2022	2/22/2022	47	83
3	Гудамж, талбайн тохижилт, ногоон байгууламж /Дундговь/	2022.04.19	2023.11.01	1,000.0	100.0	АЗД	ЗГ-ын №359 тогтоол	12/1/2021	1/6/2022	2/22/2022	47	83
4	Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл /Дундговь/	2022.04.20	2022.06.20	1,000.0	200.0	АЗД	ЗГ-ын №359 тогтоол	12/1/2021	1/6/2022	2/22/2022	47	83
5	“Их соёл-Эх үндэс” төсөл хөтөлбөр /Дундговь, Говьсүмбэр/	2022.05.09	2022.06.10	1,000.0	1,000.0	АЗД	ЗГ-ын №359 тогтоол	12/1/2021	1/6/2022	2/22/2022	47	83

6	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дундговь, Сайнцагаан сум, 2 дугаар цэцэрлэг/	2022.05.25	2023.08.01	3,026.0	239.6	АЗД	ЗГ-ын №359 тогтоол	12/1/2021	1/6/2022	1/11/2022	5	41
7	Наадмын талбайн барилгын дуусгал /Дундговь, Сайнцагаан сум/	2019.08.06	2020.10.26	2,000.0	469.1	АЗД	БСШУС С-н №А/69	2/14/2019	1/7/2019	4/23/2019	106	68
8	Спорт заалны барилга /Дундговь, Говь-Угтаал сум/	2019.08.06	2020.08.25	1,000.0	500.0	АЗД	БСШУС С-н №А/69	2/14/2019	1/14/2019	3/7/2019	52	21
9	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 2 км /Дундговь, Эрдэнэдалай сум/	2019.09.20	2020.10-01	1,800.0	554.9	АЗД	ЗТХЗ-н №08	1/10/2019	1/14/2019	5/2/2019	108	112
НИЙТ ДҮН				12,076.0	4,113.6							

Хавсралт 3

ЭРХ ШИЛЖИН ИРСЭН ТӨСӨЛ АРГА, ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ /ТЕНДЕРИЙН ХУГАЦАА/ СУДАЛГАА №2

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг /сая төгрөг /	Худалдан авах ажиллагаанд мөрдсөн хугацаа							
					Тендер							Хүчинтэй байх хугацаа
		Эхлэх	Дуусах		Зарлах аар төлөвлөсөн огноо	Зарласан огноо	Хэтэрсэн хоног	Тендер хүлээж авах эцсийн хугацаа	Үнэлгээний хорооны дүгнэлт	Харьцуулалт 5 хоног, Нээлттэй 30 хоног дээш хоногт хүлээж	Тендерт зарцуулсан нийт хугацаа, хоног	Тендерийн хүчинтэй байх хугацаа

									гарсан огноо	авах хугацаа			ан эсэх /тийм, үгүй/
	А	1	2	3	18	19	20=1 9-18	21	22	23=21-19	24=22- 21	25	26
1	Ноос хяргах байгууламж, тоног төхөөрөмж	2022.04. 19	2022.06.3 0	250.0	1/7/202 2	02/24/22	48	03/28/2 2	04/11/2 2	32	14	5/27/202 2	үгүй
2	“Ижий говь” төсөл хөтөлбөр	2022.04. 18	2022.06.1 5	1,000.0	1/7/202 2	2/25/22	49	3/30/20 22	04/01/2 2	33	2	4/27/202 2	үгүй
3	Гудамж, талбайн тохижилт, ногоон байгууламж /Дундговь/	2022.04. 19	2023.11.0 1	1,000.0	1/7/202 2	2/28/22	52	4/1/202 2	04/08/2 2	32	7	5/1/2022	үгүй
4	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл	2022.04. 20	2022.06.2 0	1,000.0	1/7/202 2	2/25/22	49	3/28/20 22	04/11/2 2	31	14	4/28/202 2	үгүй
5	"Их соёл-Эх үндэс" төсөл хөтөлбөр /Дундговь, Говьсүмбэр/	2022.05. 09	2022.06.1 0	1,000.0	1/7/202 2	3/16/22	68	4/18/20 22	04/28/2 2	33	10	5/18/202 2	үгүй
6	Цэцэрлэгийн барилга, 150 ортой	2022.05. 25	2023.08.0 1	3,026.0	1/7/202 2	1/14/22	7	2/14/20 22	04/21/2 2	31	66	3/16/202 2	үгүй
7	Наадмын талбайн барилгын дуусгал	2019.08. 06	2020.10.2 6	2,000.0	1/9/201 9	5/8/19	119	6/10/20 19	07/29/1 9	33	49	7/10/202 2	үгүй
8	Спорт заалны барилга /Дундговь, Говь-Угтаал сум/	2019.08. 06	2020.08.2 5	1,000.0	2/11/20 19	4/2/19	50	5/2/201 9	07/19/1 9	30	78	6/2/2019	үгүй
9	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 2 км /Дундговь, Эрдэнэдалай сум/	2019.09. 20	2020.10- 01	1,800.0	1/18/20 19	5/21/19	123	8/19/20 19	08/19/1 9	90	0	9/19/201 9	үгүй
	НИЙТ ДҮН			12,076. 0									

Хавсралт 4

ЭРХ ШИЛЖИН ИРСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ / ГЭРЭЭ БАЙГУУЛАХ/ ХУГАЦААНЫ
СУДАЛГАА №3

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг / сая төгрөг/	ХАА мөрдсөн хугацаа					
		Эхлэх	Дуусах		Гэрээ байгуулах эрх олгох			Гэрээний		
					Төлөвлөсөн огноо	Эрх олгосон огноо	Үүнээс, хэтэрсэн хоног	Байгуулахаар төлөвлөсөн огноо	Байгуулсан огноо	Үүнээс, хэтэрсэн хоног
	А	1	2	3	29	30	31=30-29	32	33	34=33-32
1	Ноос хяргах байгууламж, тоног төхөөрөмж /Дундговь, Хулд сум/	2022.04.19	2022.06.30	250.0	2/12/2022	4/12/2022	59	4/12/2022	4/19/2022	7
2	“Ижий говь” төсөл хөтөлбөр /Дундговь/	2022.04.18	2022.06.15	1,000.0	2/12/2022	4/11/2022	58	4/11/2022	4/18/2022	7
3	Гудамж, талбайн тохижилт, ногоон байгууламж /Дундговь/	2022.04.19	2023.11.01	1,000.0	2/12/2022	4/12/2022	59	4/12/2022	4/19/2022	7
4	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Дундговь/	2022.04.20	2022.06.20	1,000.0	2/12/2022	4/12/2022	59	4/12/2022	4/20/2022	8
5	"Их соёл-Эх үндэс" төсөл хөтөлбөр /Дундговь, Говьсүмбэр/	2022.05.09	2022.06.10	1,000.0	2/12/2022	4/29/2022	76	4/29/2022	5/9/2022	10
6	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дундговь, Сайнцагаан сум, 2 дугаар цэцэрлэг/	2022.05.25	2023.08.01	3,026.0	2/12/2022	4/25/2022	72	4/25/2022	5/4/2022	9

7	Наадмын талбайн барилгын дуусгал /Дундговь, Сайнцагаан сум/	2019.08.06	2020.10.26	2,000.0	2/13/2019	7/30/2019	167	7/30/2019	8/7/2019	8
8	Спорт заалны барилга /Дундговь, Говь-Угтаал сум/	2019.08.06	2020.08.25	1,000.0	3/29/2019	7/25/2019	118	7/25/2019	8/6/2019	12
9	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 2 км /Дундговь, Эрдэнэдалай сум/	2019.09.20	2020.10-01	1,800.0	Шууд гэрээ			3/20/2019	9/20/2019	184
НИЙТ ДҮН				12,076.0						

Хавсралт 5

ЭРХ ШИЛЖИН ИРСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ / ТЕНДЕРИЙН ҮР ДҮН/ СУДАЛГАА №4

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг / сая төгрөг /	ТЕЗ-ийн нэр	Эрх шилжүүлсэн шийдвэр, огноо, дугаар		ХАА-нд мөрдөгдсөн журам				ХАА-г зарласан хэлбэр		Шалгарсан гүйцэтгэгчийн нэр	Шалгарсан төсөвт өртгийн дүн
								Нээлттэй	Тендер шалгаруулалтын онцгой журам						
		Эхлэх	Дуусах			ТЕЗ-ийн	ТЕЗ-ийн огноо, дугаар		Хязгаарлагдмал	Харьцуулалт	Түлхүүр гардуулах	Уламжлалт	Цахим		

						шийд вэр									
	A	1	2	3	5	7	7	8	9	10	11	12	13	37	38
1	Ноос хяргах байгууламж, тоног төхөөрөмж /Дундговь, Хулд сум/	2022.04.1 9	2022.06.3 0	250.0	A3Д	ЗГ- ын №35 9 тогт оол	2021.12.01				Тий м		Цахим	Энх өргөө	219.8
2	“Ижгий говь” төсөл хөтөлбөр /Дундговь/	2022.04.1 8	2022.06.1 5	1,000.0	A3Д	ЗГ- ын №35 9 тогт оол	2021.12.01	Тий м					Цахим	Хоббизоон	997.5
3	Гудамж, талбайн тохижилт, ногоон байгууламж /Дундговь/	2022.04.1 9	2023.11.0 1	1,000.0	A3Д	ЗГ- ын №35 9 тогт оол	2021.12.01				Тий м		Цахим	Тэнгисийн шүр	888.1
4	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Дундговь/	2022.04.2 0	2022.06.2 0	1,000.0	A3Д	ЗГ- ын №35 9 тогт оол	2021.12.01	Тий м					Цахим	Сорьц хаус	704.0

5	"Их соёл-Эх үндэс" төсөл хөтөлбөр /Дундговь, Говьсүмбэр/	2022.05.09	2022.06.10	1,000.0	АЗД	ЗГ-ын №359 тогтоол	2021.12.01	Тийм					Цахим	Саммит компьютер технологи	798.3
6	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дундговь, Сайнцагаан сум, 2 дугаар цэцэрлэг/	2022.05.25	2023.08.01	3,026.0	АЗД	ЗГ-ын №359 тогтоол	2021.12.01	Тийм					Цахим	Энх баялаг констракшн	2,710.0
7	Наадмын талбайн барилгын дуусгал /Дундговь, Сайнцагаан сум/	2019.08.06	2020.10.26	2,000.0	АЗД	БСШ УСС-н №А/69	2/14/2019	Тийм					Цахим	Зуут констракшн	1,940.5
8	Спорт заалны барилга /Дундговь, Говь-Угтаал сум/	2019.08.06	2020.08.25	1,000.0	АЗД	БСШ УСС-н №А/69	2/14/2019	Тийм					Цахим	Бум констракшн	853.2
9	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 2 км /Дундговь, Эрдэнэдалай сум/	2019.09.20	2020.10-01	1,800.0	АЗД	ЗТХЗ-н №08	1/10/2019	Тийм					Цахим	Өлзий хутгийн наран	1,294.7

НИЙТ ДҮН			12,076. 0											10,406.1
----------	--	--	--------------	--	--	--	--	--	--	--	--	--	--	----------

Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сүм, Нарлаг
баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39
E-mail: dundgovi@audit.gov.mn ОН